



CoordinatePro
Consultants
Audit LLC

УВС ХҮНС

Хувьцаат Компани

Тусдаа санхүүгийн тайлан ба
Хараат бус Аудиторын тайлан

2025 оны 12 сарын 31 -нээр тасалбар болгосон тайлант жилийн

“УВС ХҮНС” ХК

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛ

АГУУЛГА

ХУУДАС

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

1 – 2

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

3

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

4

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

5

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

6

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

7-28


“УВС ХҮНС” ХК

УДИРДЛАГЫН ХАРИУЦЛАГЫН МЭДЭГДЭЛ

“УВС ХҮНС” ХК (цаашид “Компани” гэх) -ийн Гүйцэтгэх захирал Л.Нямгэрэл Санхүү албаны дарга Я.Мөнхжаргал бид, энэхүү тайлангийн 3-6 дугаар хуудсанд тусгагдсан Компанийн санхүүгийн тайланд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Компанийн санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын Зөвлөл (СТОУСЗ) -өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартуудын (СТОУС) дагуу үнэн зөв, иж бүрэн, бодитойгоор илэрхийлсэн болохыг үүгээр баталж байна. Үүнд:

1. Бүх ажил гүйлгээ бодитоор гарсан бөгөөд холбогдох анхан шатны баримтыг үндэслэн нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд үнэн зөв тусгасан,
2. Санхүүгийн тайланд тусгагдсан бүх тооцоолол үнэн зөв хийгдсэн,
3. Аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны эдийн засаг, санхүүгийн бүхий л үйл явцыг иж бүрэн хамарсан,
4. Тайлант үеийн үр дүнд өмнөх оны ажил гүйлгээнээс шилжин тусгагдаагүй, мөн тайлант оны ажил гүйлгээнээс орхигдсон зүйл байхгүй,
5. Бүх хөрөнгө, авлага, өр төлбөр, орлого, зардлыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв тусгасан,
6. Холбоотой талуудын харилцаа болон ажил гүйлгээнүүдийг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу зохих ёсоор бүртгэн тооцож, тодруулсан,
7. Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартаар тохируулга эсвэл тодруулга хийхийг шаарддаг, 2025 оны 12-р сарын 31 –нээс хойших бүх үйл явдлыг тохируулсан буюу тодруулсан,
8. Энэ тайланд тусгагдсан бүхий л зүйл манай компанийн албан ёсны өмчлөлд байдаг бөгөөд орхигдсон зүйл үгүй болно.

Компанийн удирдлагаас “УВС ХҮНС” ХК -ийн 2025 оны 12 дугаар сарын 31 -ний өдрөөр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайланг нийтэд толилуулахыг зөвшөөрч байна.


Гүйцэтгэх захирал
Санхүү албаны дарга

Улаанбаатар хот, Монгол Улс

Огноо: 2026 оны 4 дүгээр сарын 8 өдөр



ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“УВС ХҮНС” ХК -ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Дүгнэлт

Бид “УВС ХҮНС” ХК –ийн 2025 оны 12 дугаар сарын 31 –ний өдрөөрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр дуусгавар болсон жилийн Ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, Өмчийн өөрчлөлтийн тайлан, Мөнгөн гүйлгээний тайлан, эдгээр санхүүгийн тайлантай холбоотой нягтлан бодох бүртгэлийн гол бодлогууд, бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр, тус компанийн Санхүүгийн тайлангууд нь компанийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, энэ өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн үр дүн болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт /СТОУС/ -ын дагуу үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт /АОУС/ -ын дагуу гүйцэтгэлээ. Энэ стандартын дагуу хүлээх хариуцлагаа энэхүү тайлангийн “Санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага” хэсэгт тайлбарласан. Бид Монгол улсад мөрдөгддөг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус бөгөөд эдгээр шаардлагуудын дагуу тавигддаг ёс зүйн бусад хариуцлагаа бүрэн биелүүлсэн. Бидний олж авсан аудитын нотолгоо нь дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой үндэслэл болно гэж найдаж байна.

Санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн үүрэг

Санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэж, толилуулах нь компанийн удирдлагын үүрэг болно. Энэхүү үүрэг хариуцлагад залилан болон алдаанаас үүдэлтэй материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд шаардлагатай дотоод хяналтыг тогтоох үүрэг орно.

Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ удирдлага нь компанийг татан буулгах, түүний үйл ажиллагааг зогсоохоор төлөвлөж байгаа эсвэл эдгээрийг хийхээс өөр боломжит арга зам байхгүй байгаагаас бусад үед компани нь үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлэх чадвар, илчлэл, шаардлагатай бол энэхүү тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг хэрэглэхтэй холбоотой асуудлуудыг үнэлэх үүрэгтэй.

Засаглал хариуцсан этгээдүүд компанийн санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын Олон Улсын Стандартын дагуу гүйцэтгэсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

“УВС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДЭД

Санхүүгийн тайлангуудын аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудыг үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ.

АОУС – ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Компанийн дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоо тооцооллууд, холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Компанийн үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал, нөхцөл байдал компанийн тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Компанийн санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.
- Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын “Компанийн тухай хууль”-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Компанийн хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн, Компанийн хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

П.БАЯРМАА

Гүйцэтгэх захирал

Улаанбаатар хот, Монгол улс

Огноо: 2026 оны 4 дүгээр сарын 8 өдөр



КООДИНАТ ПРО КОНСАЛТАНТС АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31 БОЛОН 2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР

(төгрөгөөр)			
ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2024-12-31	2025-12-31
ХӨРӨНГӨ			
Эргэлтийн хөрөнгө			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	2	165,547,445.22	218,260,330.75
Дансны авлага	3	34,717,306.95	74,313,214.18
Татвар, НДШ -ийн авлага	4	5,524,056.15	19,453,659.84
Бусад авлага	5	792,988,395.86	776,501,766.85
Бараа материал	6	1,970,042,138.81	3,365,330,586.47
Урьдчилж төлсөн зардал / тооцоо	7	61,059,462.87	75,552,864.91
Эргэлтийн хөрөнгийн дүн		3,029,878,805.86	4,529,412,423.00
Эргэлтийн бус хөрөнгө			
Үндсэн хөрөнгө	8	1,685,945,770.43	1,587,910,602.01
Биет бус хөрөнгө	9	194,689,447.15	236,069,158.02
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		1,880,635,217.58	1,823,979,760.03
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН		4,910,514,023.44	6,353,392,183.03
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
Богино хугацаат өр төлбөр			
Дансны өглөг	10	8,968,855.61	21,498,177.86
Цалингийн өглөг	11	40,040,301.33	37,384,324.29
Татвар хураамжийн өр төлбөр	12	116,014,303.65	170,586,598.89
НДШ -ийн өр төлбөр	13	1,814,607.23	20,828,514.39
Богино хугацаат зээл	14	275,000,000.00	0.00
Хүүний өглөг	15	65,479.45	0.00
Богино хугацаат өр төлбөрийн дүн		441,903,547.27	250,297,615.43
Урт хугацаат өр төлбөр			
Урт хугацаат өр төлбөрийн дүн		0.00	0.00
ӨР ТӨЛБӨРИЙН НИЙТ ДҮН		441,903,547.27	250,297,615.43
ЭЗДИЙН ӨМЧ			
Өмч : - Төрийн		0.00	0.00
- Хувийн	17	11,271,600.00	11,271,600.00
Нэмж төлөгдсөн капитал	18	3,465,126.06	3,465,126.06
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	19	847,420,494.00	847,420,494.00
Эздийн өмчийн бусад хэсэг	20	179,179,658.00	179,179,658.00
Хуримтлагдсан ашиг	21	3,427,273,598.11	5,061,757,689.54
ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		4,468,610,476.17	6,103,094,567.60
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН		4,910,514,023.44	6,353,392,183.03

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

АШИГ, АЛДАГДАЛ БА БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

(төгрөгөөр)			
ҮЗҮҮЛЭЛТ	СТТ	2024	2025
БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО (ЦЭВЭР)	22	5,592,134,350.64	7,798,624,845.29
Борлуулалтын өртөг	22	3,206,906,508.99	4,417,453,834.52
НИЙТ АШИГ (АЛДАГДАЛ)		2,385,227,841.65	3,381,171,010.77
Хүүний орлого	24	0.00	14,806,647.80
		0.00	14,806,647.80
Борлуулалт маркетингийн зардал	25	305,762,205.06	326,530,194.38
Ерөнхий ба удирдлагын зардал	26	952,363,743.09	1,169,879,077.92
Санхүүгийн зардал	27	58,461,625.90	53,798,042.66
Бусад зардал	27	22,390,454.12	28,305,779.34
		1,338,978,028.17	1,578,513,094.30
Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	28	993,125.40	1,655,134.04
Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	29	2,591,222.44	(65,080.58)
		3,584,347.84	1,590,053.46
ТАТВАР ТӨЛӨХИЙН ӨМНӨХ АШИГ (АЛДАГДАЛ)		1,049,834,161.32	1,819,054,617.73
Орлогын татварын зардал	30	107,123,147.34	184,570,526.30
ЕРДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАТВАРЫН ДАРААХЬ АШИГ (АЛДАГДАЛ)		942,711,013.98	1,634,484,091.43
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал)			0.00
ТАЙЛАНТ ҮЕИЙН ЦЭВЭР АШИГ (АЛДАГДАЛ)		942,711,013.98	1,634,484,091.43
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГО		0.00	0.00
НИЙТ ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ДҮН		942,711,013.98	1,634,484,091.43
НЭГЖ ХУВЬЦААНД НООГДОХ СУУРЬ АШИГ (АЛДАГДАЛ)		8,363.60	14,501.00

“УВС ХҮНС” ХК

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

(төгрөгөөр)						
ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Нэмэгдэж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2023 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	11,271,600.00	3,465,126.06	847,420,494.00	179,179,658.00	2,484,562,584.13	3,525,899,462.19
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга						0.00
Залруулсан үлдэгдэл	11,271,600.00	3,465,126.06	847,420,494.00	179,179,658.00	2,484,562,584.13	3,525,899,462.19
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					942,711,013.98	942,711,013.98
Бусад дэлгэрэнгүй орлого						0.00
Өмчид гарсан өөрчлөлт						0.00
Зарласан ногдол ашиг						0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						0.00
2024 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	11,271,600.00	3,465,126.06	847,420,494.00	179,179,658.00	3,427,273,598.11	4,468,610,476.17
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга					0.00	0.00
Залруулсан үлдэгдэл	11,271,600.00	3,465,126.06	847,420,494.00	179,179,658.00	3,427,273,598.11	4,468,610,476.17
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)					1,634,484,091.43	1,634,484,091.43
Бусад дэлгэрэнгүй орлого						0.00
Өмчид гарсан өөрчлөлт						0.00
Зарласан ногдол ашиг						0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн						0.00
2025 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	11,271,600.00	3,465,126.06	847,420,494.00	179,179,658.00	5,061,757,689.54	6,103,094,567.60

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛГОСОН ТАЙЛАНТ ЖИЛ

(төгрөгөөр)		
ҮЗҮҮЛЭЛТ	2024	2025
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	6,124,500,381.94	9,222,303,921.21
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	6,124,500,381.94	9,222,303,921.21
Мөнгөн зарлагын дүн (-)	5,155,086,698.46	8,705,782,153.92
Ажиллагсдад төлсөн	724,632,704.00	1,009,071,754.00
Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	186,200,000.00	202,950,000.00
Бараа материал худалдан авахад төлсөн	2,586,675,337.32	4,149,124,895.99
Ашиглалтын зардалд төлсөн	132,578,947.74	169,698,646.22
Түлш, шатахуун, тээв.хөлс, сэл.хэр -д төлсөн	99,794,759.86	192,018,155.60
Хүүний төлбөрт төлсөн	60,982,796.34	13,357,814.02
Татварын байгууллагад төлсөн	919,510,566.72	1,329,379,965.59
Даатгалын төлбөрт төлсөн	2,222,310.00	1,378,764.00
Бусад мөнгөн зарлага	442,489,276.48	1,638,802,158.50
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	969,413,683.48	516,521,767.29
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	14,806,647.80
Хүлээн авсан хүүний орлого		14,806,647.80
Мөнгөн зарлагын дүн (-)	51,227,600.00	205,270,664.00
Үндсэн хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн	41,213,200.00	189,455,524.00
Биет бус хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн	10,014,400.00	15,815,140.00
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(51,227,600.00)	(190,464,016.20)
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00
Мөнгөн зарлагын дүн (-)	783,025,838.43	275,000,000.00
Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	783,025,838.43	275,000,000.00
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(783,025,838.43)	(275,000,000.00)
Валютын ханшийн зөрүү	993,142.07	1,655,134.04
БҮХ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	136,153,387.12	52,712,885.13
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	29,394,058.10	165,547,445.22
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	165,547,445.22	218,260,330.75

Хавсаргасан тодруулга нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО

1.1 САНХҮҮГИЙН ТАЙЛАНГ БЭЛТГЭХ ҮНДЭСЛЭЛ

Нийцтэй байдлын мэдэгдэл

Санхүүгийн тайланг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс баталсан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС) болон түүнд нийцүүлэн Монгол улсын Сангийн сайдын 2017 оны 361 дүгээр тушаалаар батлагдсан "Санхүүгийн тайлангийн маягт", "Санхүүгийн тайлан, тодруулгыг бэлтгэх заавар" -ын дагуу бэлтгэсэн байна.

Хэмжилтийн суурь

Санхүүгийн тайлангууд нь бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хэрэгслүүдээс бусад зүйлсийн хувьд нягтлан бодох бүртгэлийн түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

Тайлагнагч валют

Санхүүгийн тайлангуудыг Монгол улсад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгж байгууллагын тайлагнах валют болох Монгол улсын мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлсэн.

Тасралтгүй үйл ажиллагаа

Санхүүгийн тайлангууд нь тасралтгүй үйл ажиллагааны зарчимд суурилан бэлтгэгдсэн.

Нягтлан бодох бүртгэлийн томоохон тооцоолол ба үнэлгээний хэрэглээ

Санхүүгийн тайланг СТОУС-ын дагуу бэлтгэх нь удирдлагаас нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ болон хөрөнгө, өр төлбөр, орлого, зардлын тайлагнасан дүнд нөлөөлөх үнэлгээ, таамаглал, тооцоолол хийхийг шаарддаг. Бодит үр дүн нь эдгээр тооцооллоос ялгаатай байж болно.

Үнэлгээ тооцоолол болон гол чухал таамаглалууд нь байнга шалгагдаж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг тухайн өөрчлөлт хийсэн болон ирээдүйд нөлөөлөх тайлант үеүдэд нь хүлээн зөвшөөрдөг.

Санхүүгийн тайланд тусгагдсан тоон үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлэхээр нягтлан бодох бүртгэлийн бодлогын хэрэглээ, тооцооллын эргэлзээтэй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Компани нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварын дарааллаар толилуулсан.

Зөвхөн хуулиар эрх олгосон тохиолдолд хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа л бол хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр санхүүгийн байдлын тайланд толилуулна. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсвэл тайлбараар шаардсан эсвэл зөвшөөрч Компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогод тусгайлан тодруулснаас бусад тохиолдолд орлого, зарлагыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд цэвэршүүлэн тайлагнаж болохгүй.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

1) Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө

Кассад байгаа бэлэн мөнгө, банкинд байршуулсан бэлэн мөнгөнөөс (3 сар хүртэлх сарын хугацаатай хадгаламж) бүрдэнэ. Мөнгөтэй адилтгах хөрөнгө нь үнэ цэнийн өөрчлөлтийн маш бага эрсдэлтэй, мөнгөний тодорхой дүнд чөлөөтэй хөрвөх боломжтой богино хугацаат, хөрвөх чадвар сайтай хөрөнгө болно.

2) Худалдааны болон бусад авлага

Бэлэн мөнгө хүлээн авах гэрээт эрх үүсэх буюу өөр нэг аж ахуйн нэгжээс санхүүгийн хөрөнгийг авах эрх үүссэн тохиолдолд худалдааны болон бусад авлагуудыг эхэндээ өртгөөр нь бүртгэдэг. Дараа үеүдэд худалдааны болон бусад авлага нь үнэ цэнийн бууралтыг хассан цэвэр боломжит үнэ цэнээрээ тусгагддаг.

3) Бараа материал

Бараа материалын худалдан авалтын өртөгт худалдан авалтын бүх өртөг зардал, тухайн бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдон гарсан бусад зардал орно. Бараа материалыг өртөг болон цэвэр боломжит үнийн аль багаар нь тусгана.

Цэвэр боломжит үнийг тооцоход бизнесийн хэвийн нөхцөл дэх тооцоолсон борлуулах үнээс түүнийг иж бүрдэл болгоход тооцсон зардал болон борлуулалтын зардлыг хасаж тооцно.

Бараа материалын өртөг

Бараа материалын өртөг нь худалдан авалтын бүх өртөг зардал хувиргалтын зардал болон тухайн бараа материалыг түүний одоогийн байршил ба төлөв байдалд оруулахтай холбогдож гарсан бусад зардлаас бүрддэг.

- 8 -

Худалдан авалтын зардал

Бараа материалын худалдан авалтын өртөг нь худалдан авсан үнэ импортын татвар ба бусад татвар (татварын эрх бүхий байгууллагаас тухайн аж ахуйн нэгж дараа нь нөхөж авахаас бусад), тээвэрлэлт, ачиж буулгах зардал болон бэлэн бүтээгдэхүүн, материал, үйлчилгээний худалдан авалтад шууд хамаарах бусад зардлаас бүрддэг. Худалдан авалтын өртгийг тодорхойлохдоо худалдааны хөнгөлөлт, урамшуулал болон бусад адилтгах зүйлийг хасна.

Хувиргалтын зардал

Бараа материалын хувиргалтын зардал нь шууд хөдөлмөр гэх мэт бүтээгдэхүүний үйлдвэрлэлд шууд хамааралтай зардлаас бүрддэг. Мөн материалыг бэлэн бүтээгдэхүүн болгон худиргахад гардаг үйлдвэрлэлийн тогтмол ба хувьсах нэмэгдэл зардлын системчилсэн хувиарлалт нь хувиргалтын зардалд хамаардаг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

3) Бараа материал (үргэлжлэл)

Хувиргалтын зардал (үргэлжлэл)

Үйлдвэрлэлийн тогтмол нэмэгдэл зардал нь үйлдвэрлэлийн процесст ашиглагдаж байгаа үйлдвэрийн барилга, тоног төхөөрөмж, хөрөнгийг ашиглах эрхийн хорогдуулга болон засварын зардал, үйлдвэрийн удирдлага ба захиргааны зардал гэх мэт үйлдвэрлэлийн тоо хэмжээнээс үл хамааран харьцангуй тогтвортой байдаг үйлдвэрлэлийн шууд бус зардлууд юм. Үйлдвэрлэлийн хувьсах нэмэгдэл зардал нь үйлдвэрлэлийн тоо хэмжээнээс шууд эсвэл ойролцоогоор шууд хамааран өөрчлөгддөг шууд бус хөдөлмөр, шууд бус материалын зардал гэх мэт үйлдвэрлэлийн шууд бус зардлууд юм.

Үйлдвэрлэлийн тогтмол нэмэгдэл зардлыг хувиргалтын зардалд шингээх хувиарлалт нь тухайн үйлдвэрлэлийн хэрэгслийн хэвийн хүчин чадалд үндэслэдэг. Хэвийн хүчин чадал гэдэг нь төлөвлөсөн засвар үйлчилгээний улмаас гарах хүчин чадлын алдагдлыг харгалзаж хассан бөгөөд олон тайлант үеүд буюу улирлуудын дундажаар тооцоход, хэвийн нөхцөл байдалд бий болгохоор хүлээгдэж буй үйлдвэрлэлийн тоо хэмжээ юм. Хэрэв үйлдвэрлэлийн бодит тоо хэмжээ нь хэвийн хүчин чадалтай ойролцоо байвал түүнийг тооцоололд ашиглаж болно. Үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнд хувиарлах тогтмол нэмэгдэл зардлын дүнг цөөн тоо нэмжээгээрх үйлдвэрлэл эсвэл сул зогсолтын улмаас нэмэгдүүлэхгүй. Ийм хувиарлагдаагүй үлдсэн нэмэгдэл зардлыг тухайн зардал гарсан тайлант үед зардлаар хүлээн зөвшөөрнө. Хэвийн бус их хэмжээний үйлдвэрлэл явуулсан тайлант үеүдэд тухайн бүтээгдэхүүнийг өртгөөс өндөр дүнгээр хэмжин тусгахгүйн тулд үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнд хувиарлах үйлдвэрлэлийн тогтмол нэмэгдэл зардлын дүнг бууруулна. Үйлдвэрлэлийн хувьсах нэмэгдэл зардлыг уг үйлдвэрлэлийн хэрэгслийн бодит ашиглалтад үндэслэн тухайн үйлдвэрлэсэн нэгж бүтээгдэхүүнд хуваарилдаг.

- 9 -

Үйлдвэрлэлийн процессын явцад нэгээс олон тооны бүтээгдэхүүнийг нэгэн зэрэг үйлдвэрлэдэг байж болох юм. Тухайлбал хамсарсан бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг эсвэл үндсэн ба дайвар бүтээгдэхүүнтэй байх үед ийм тохиолдол үүсдэг. Бүтээгдэхүүн тус бүрийн хувиргалтын зардлыг тусад нь тодорхойлох боломжгүй байвал хувиргалтын зардлыг оновчтой бөгөөд тогтвортой суурьт үндэслэн тэдгээр бүтээгдэхүүнд хувиарлана. Тухайлбал: бүтээгдэхүүнийг тус тусад нь тодорхойлж чадах үйлдвэрлэлийн процессын тодорхой нэг үе шатанд эсвэл үйлдвэрлэл дууссан үед бүтээгдэхүүн тус бүрийн борлуулалтын харгалзах үнэд үндэслэн ийм хувиарлалтыг хийж болно. Өөрийн шинж төрлийн дагуу ихэнх дайвар бүтээгдэхүүн нь материаллаг бус байдаг. Ийм материаллаг бус байх үед дайвар бүтээгдэхүүнийг ихэвчлэн цэвэр боломжит үнэ цэнээр хэмжих ба үнэ цэнийг үндсэн бүтээгдэхүүний өртгөөс хасдаг. Ингэснээр үндсэн бүтээгдэхүүний дансны үнэ ба түүний өртгийн хооронд материаллаг хэмжээний зөрүү үүсэхгүй.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

4) Гадаад валютаар гарсан ажил гүйлгээ

Гадаад валютаар гарсан ажил гүйлгээг тухайн жил гүйлгээ гарсан өдрийн ханшид үндэслэн Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр илэрхийлж нэгэн зэрэг бүртгэдэг.

Санхүүгийн байдлын тайлангийн мөнгөн зүйлсийг тайлант хугацааны эцэст хаалтын ханшийг үндэслэн хөрвүүлдэг. Мөнгөн зүйлсийн төлөгдсөн буюу хүлээн авсан эсвэл хөрвүүлснээс үүссэн бүх зөрүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Түүхэн өртгөөр илэрхийлэгдсэн, анх гадаад валютаар гарсан мөнгөн бус зүйлсийг түүнийг олж бэлтгэх үеийн түүхэн ханшийг ашиглан хөрвүүлж бүртгэдэг.

Гадаад валютын төгрөгтэй харьцах албан ханш:

	<u>USD</u>
2024 оны 12 дугаар сарын 31	3,420.25
2025 оны 12 дугаар сарын 31	3,556.81

5) Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр нь хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн өртөг нь худалдан авсан үнэ, импортын татвар, эргэн төлөгдөхгүй худалдан авалтын татвар болон тухайн хөрөнгийг зориулалтын ажлын байршил, нөхцөлд бэлэн болгохтой холбогдсон бусад зардал зэргээс бүрдэнэ. Хэрэв тухайн хөрөнгийн гол эд ангийн ашиглах хугацаа ялгаатай байгаа тохиолдолд тэдгээрийг салгаж тусад нь ангилдаг.

Үндсэн хөрөнгийг борлуулснаас үүссэн олз ба гарзыг борлуулж буй цэвэр үнэ болон тухайн хөрөнгийн дансны үнэ(үлдэгдэл өртөг)-тэй харьцуулж тодорхойлдог ба олз, гарзыг ашиг алдагдлын тайланд хүлээн зөвшөөрдөг.

Машин тоног төхөөрөмжийн эд ангийг дахин солих, орлуулахтай холбоотой өртгийг уг эд анги ирээдүйд эдийн засгийн үр өгөөж өгөх болон өртгийг найдвартай хэмжих боломжтой үед хөрөнгөөр хүлээн зөвшөөрнө.

Үндсэн хөрөнгийн өдөр тутмын үйлчилгээний зардлыг тухайн тайлант үеийн орлогын тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө.

6) Үндсэн хөрөнгийн элэгдэл

Үндсэн хөрөнгийг ашиглагдах хугацаанд нь шулуун шугамын аргаар элэгдүүлж, элэгдлийн зардлыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд тусгана. Үндсэн хөрөнгийг ашиглахаар тогтоосон хугацаа нь дараах байдалтай байна.

- | | |
|--------------------------------------|-----------|
| • Барилга байгууламж | 25-40 жил |
| • Тээврийн хэрэгсэл | 10 жил |
| • Тоног төхөөрөмж | 3-10 жил |
| • Тавилга, эд хогшил | 10 жил |
| • Компьютер түүний дагалдах хэрэгсэл | 2-10 жил |

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

7) Түрээсэлсэн хөрөнгө

Тухайлсан хөрөнгийг зөвшөөрсөн хугацаанд ашиглах эрхийг тодорхой төлбөртэйгөөр шилжүүлэх хэлцэл гэж компани нь тодорхойлж байгаа нөхцөлд ажил гүйлгээ буюу бүлэг ажил гүйлгээнээс бүрдэх хэлцлийг түрээс гэж үздэг. Тухайн тохиолдолд хэлцлийн шинж байдлыг үнэлсний үр дүнд хийдэг бөгөөд энэ хэлцэл нь түрээсийг хууль зүйн хэлбэртэй эсэхээс үл хамаарна.

Компанийн түрээсэлж буй хөрөнгийн ангилал

- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг шилжүүлэх нөхцөлтэй бол санхүүгийн түрээсээр,
- Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг бүрэн шилжүүлэх нөхцөлгүй түрээсийг үйл ажиллагааны түрээсээр ангилна.

Хөрөнгийн өмчлөлтэй холбогдсон бүх эрсдэл болон өгөөжийг бүрэн шилжүүлэх үед үүсэх санхүүгийн түрээсийг түрээсэлсэн хөрөнгийн зах зээлийн бодит үнэ цэнээр эсвэл түрээсийн хамгийн бага төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээс эхэлсэн үед нь хүлээн зөвшөөрдөг.

Түрээсийн төлбөрүүд нь санхүүгийн зардал ба түрээсийн өглөгийн бууралтад хуваагдах бөгөөд өглөгийн эцсийн үлдэгдэлд тогтмол хүү тооцдог. Санхүүгийн зардлыг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрдөг.

Түрээсэлсэн хөрөнгийг нь хөрөнгийн ашиглалтын хугацааны турш элэгдүүлдэг. Түрээсийн хугацааны эцэст эзэмшил нь компанид шилжих эсэх нь тодорхойгүй үед хөрөнгийг ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаагаар элэгдүүлдэг.

Үйл ажиллагааны түрээс

- 11

Компани нь үйл ажиллагааны түрээсийн дагуу эзэмших хөрөнгө ашиглаж буй тохиолдолд түрээсийн дагуу хийгдсэн төлбөрүүдийг түрээсийн хугацааны тайлант үеүдэд тэнцүү хэмжээгээр орлого зардлаар тайлагнадаг.

8) Сангууд

Компанид (а) өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг (хууль, ёс зүйн) байгаа (б) энэхүү үүргээ биелүүлэхэд эдийн засгийн өгөөж агуулсан баялгийг зарцуулах нь тодорхой болсон ба үүргийн дүнг бодитойгоор ойролцоолон тооцоолох боломжтой үед санг хүлээн зөвшөөрнө. Компани нь байгуулсан сангийн зарим хэсгийг эсвэл бүгдийг нөхөн төлбөрт зарцуулахаар хүлээж байгаа үед нөхөн төлбөр хийх нь бодитой болсон үед л зөвхөн төлбөрийг тусдаа хөрөнгө болгон хүлээн зөвшөөрнө. Аливаа нэг сантай холбоотой зардлыг ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

9) Санхүүгийн хэрэглүүр

(i) Хүлээн зөвшөөрөх өдөр

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анх хүлээн зөвшөөрөхдөө ажил гүйлгээ хийсэн өдөр хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан бодит үнэ цэнээр бүртгэх ба тухайн бодит үнэ цэнэ эсвэл хүлээн авсан Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдээс бусад санхүүгийн хэрэглүүрүүдийг анхлан хэмжихдээ гүйлгээний зардлыг нэмсэн дүнгээр хэмжинэ. Компанийн санхүүгийн хөрөнгөд зээл ба авлага орно.

(ii) Зээл ба авлага

Зээл ба авлага нь идэвхитэй зах зээлд бүртгэлгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөр бүхий үүсмэл санхүүгийн хэрэглүүр бус санхүүгийн хөрөнгө юм.

Анх хүлээн зөвшөөрсний дараа санхүүгийн хөрөнгийг хэмжихдээ:

1. Хорогдуулсан өртгөөр
2. Бусад дэлгэрэнгүй орлогоор дамжуулан бодит үнэ цэнээр үнээр
3. Ашиг алдагдлаар дамжуулан бодит үнэ цэнээр тус тус хэмжинэ.

Хэмжилтийн сонголт нь санхүүгийн хөрөнгийг удирдан зохицуулах тухайн аж ахуйн нэгжийн бизнесийн загвар, гэрээний мөнгөн гүйлгээний шинж чанараас хамаарна.

Санхүүгийн хөрөнгө нь мөнгө, худалдааны ба бусад авлага, борлуулахад бэлэн байгаа үнэт цаас болон бусад санхүүгийн хэрэгслээс бүрдэнэ.

10) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт

(i) Санхүүгийн хөрөнгө

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (хэрэглэх боломжтой бол, санхүүгийн хөрөнгийн хэсгийг эсвэл хоорондоо төсөөтэй нэг бүлэг санхүүгийн хөрөнгүүдийн хэсгийг) үл хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсвэл
- Компани тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулалгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсвэл
- Компани хөрөнгийн дийлэнхи эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсвэл
- Компани тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл, өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

10) Санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт (үргэлжлэл)

(i) Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Компани хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсвэл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Компанийн уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Компани холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөр Компанийн хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ. Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Компанийн төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

(ii) Санхүүгийн өр төлбөр

Компанийн санхүүгийн өр төлбөрүүдэд зээллэг, үүсмэл санхүүгийн өр төлбөр, хүүгийн өглөг дансны болон бусад өр төлбөр орно.

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсвэл хугацаа нь дууссан бол үл хүлээн зөвшөөрдөг.

Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсвэл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг анхны санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрөлт гэж үзнэ.

11) Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ

Бодит үнэ цэнэ гэдэг нь хэмжилт хийсэн өдрийн зах зээлд оролцогчдын хооронд зохих журмын дагуу хөрөнгө борлуулснаас орж ирэх эсвэл өр төлбөрийг шилжүүлэхэд төлж буй үнийг бодит үнэ байна.

Бодит үнэ цэнийн хэмжилтийг дараах тохиолдлуудад болж буй хөрөнгийг борлуулах эсвэл өр төлбөрийг шилжүүлэх гүйлгээнд үндэслэн хийдэг. Үүнд:

- Хөрөнгө ба өр төлбөрийн үндсэн зах зээлд, эсвэл
- Үндсэн зах зээл байхгүй тохиолдолд, хөрөнгө ба өр төлбөрийн хувьд хамгийн давуу зах зээлд

Үндсэн зах зээл болон хамгийн давуу зах зээл нь Компанийн хувьд оролцож болохуйц зах зээл байх ёстой.

Хөрөнгө ба өр төлбөрийн бодит үнэ цэнийг хэмжихэд ашигласан үнэ нь зах зээлд оролцогчид нь хөрөнгө ба өр төлбөрийн эдийн засгийн хамгийн өндөр үр өгөөжийг хүртэнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэдэг.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

11) Санхүүгийн хэрэгслийн бодит үнэ цэнэ (үргэлжлэл)

Санхүүгийн бус хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг, тухайн зах зээлд оролцогч тал нь хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг хүртэж чадах эсвэл уг хөрөнгийг борлуулснаар худалдан авсан талд уг хөрөнгийг ашигласнаар хамгийн өндөр эдийн засгийн үр өгөөжийг өгөх нөхцөлд тооцно.

Компани нь бодит үнэ цэнэ тооцоход шаардлагатай орцууд хангалттай үед үнэлгээний техникүүдийг хэрэглэх нь тохиромжтой байдаг ба ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг нэмэгдүүлж, үл ажиглагдахуйц өгөгдлийн хэрэглээг хамгийн багаар ашиглана.

Санхүүгийн тайланд хэмжиж, тодруулсан бүх үндсэн хөрөнгө болон өр төлбөрүүдийг бодит үнэ цэнийн түвшинд дараах байдлаар ангилсан ба ангилахдаа бодит үнэ цэнийн хэмжүүрт бүхлээрээ томоохон нөлөөтэй, хамгийн бага түвшний орцод үндэслэн:

Түвшин 1 - Хөрөнгө, өр төлбөрийн хувьд хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй (залруулаагүй), идэвхитэй зах зээл дээрх үнэ,

Түвшин 2 - Шууд болон шууд бусаар ажиглах боломжтой хамгийн бага түвшний орцууд нь бодит үнэ цэнэд томоохон нөлөөтэй үнэлгээний техникүүд

Түвшин 3 - Ажиглах боломжгүй хамгийн бага түвшний орц нь бодит үнэ цэнийн хэмжилтэнд томоохон нөлөөтэй үнэлгээний техникүүд

Тайлант хугацааны эцэст Компани нь санхүүгийн тайландаа тайлагнасан хөрөнгө, өр төлбөрийн хувьд түвшин хооронд хөдөлгөөн гарсан эсэхийг дахин нягталж үздэг (бодит үнэ цэнийн хэмжилтэд нөлөөлөхүйц хамгийн бага түвшний өгөгдөлд үндэслэн).

10) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

- 14

Компани нь тайлангийн өдөр бүр хөрөнгө үнэ цэнийн бууралтанд орох шинж тэмдэг байгаа эсэхийг үнэлнэ. Хэрэв хөрөнгийг анхлан хүлээн зөвшөөрсний дараа нэг буюу түүнээс олон тооны "Алдагдлын тохиолдол"-ын улмаас үнэ цэнийн бууралтын бодит шинж тэмдэг бий болсон ба уг "Алдагдлын тохиолдол" нь санхүүгийн хөрөнгө эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн ойролцоолон тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлж байгаа үед санхүүгийн хөрөнгийг эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзнэ.

Хөрөнгийн эсвэл бэлэн мөнгө бий болгогч нэгжийн дансны дүн нь цуглуулан авах дүнгээс илүү байгаа үед хөрөнгийг үнэ цэнийн бууралтад орсон гэж үзэн цуглуулан авах дүн хүртэл нь бууруулж бүртгэнэ. Ашиглалтын үнийг үнэлэхдээ, тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ ба хөрөнгөд харгалзах эрсдэлүүдийн талаарх өнөөгийн зах зээлийн үнэлгээнүүдийг тусгасан татварын өмнөх хөнгөлөлтийн хувь хэмжээгээр бууруулан өнөөгийн үнэ цэнийг тодорхойлно.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

12) Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (үргэлжлэл)

(i) Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүд

Хорогдуулсан өртгөөр нь бүртгэх санхүүгийн хөрөнгүүдийн хувьд Компани эхлээд дангаараа чухал ач холбогдолтой санхүүгийн хөрөнгө тус бүрийн хувьд үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байгаа эсэхийг нэг бүрчлэн (тусгайлан), дараа нь дангаараа чухал ач холбогдолгүй санхүүгийн хөрөнгийг нийлүүлэн (бүлгээр нь) үнэлнэ.

Хэрэв Компани нь нэг бүрчлэн үнэлэгдсэн санхүүгийн хөрөнгийн үнэлгээний хувьд (чухал ач холбогдолтой, холбогдолгүй эсэхийг үл харгалзан) үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй гэж үзвэл ойролцоо зээлийн эрсдлийн шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгийн бүлэгт оруулан үнэ цэнийн бууралтыг нь нэгдсэн байдлаар үнэлдэг. Үнэ цэнийн бууралтыг нэг бүрчлэн үнэлсэн, үнэ цэнийн бууралтын алдагдал нь хүлээн зөвшөөрөгдсөн, эсвэл үргэлжилж буй хөрөнгийг бүлгийн үнэ цэнийн бууралтын үнэлгээнд оруулахгүй.

Хэрэв үнэ цэнэ буурсан талаарх бодит нотолгоо байгаа бол үнэ цэнийн бууралтын гарзыг хөрөнгийн дансны үнэ болон ирээдүйн тооцсон мөнгөн урсгалын (тохиолдоогүй байгаа ирээдүйн, хүлээгдэж буй үнэ цэнийн бууралтын гарзыг оруулахгүй) өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр хэмжинэ.

Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдэлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө. Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулахдаа үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашигласан хүүний хувиар тооцон хуримтлуулна.

Цаашид эргэн төлөгдөх ямар нэг бодит чиг хандлага байхгүй байгаа, бүх барьцаа хөрөнгийг борлуулсан эсвэл Компанид шилжүүлсэн үед, зээлийг холбогдох зээлийн эрсдэлийн сангийн хамт данснаас хасна. Хэрэв дараагийн тайлант хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараах үйл явдлын улмаас тооцоолсон ~~үнэ~~ цэнийн бууралтын алдагдал өсөж эсвэл буурвал, сангийн дансыг залруулах замаар өмнө хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтыг өсгөж эсвэл бууруулна. Өмнөх жилүүдэд данснаас хассан хөрөнгө дараа нь эргэн төлөгдвөл эргэн төлөгдсөн дүнг ашиг, алдагдлын тайланд орлогоор хүлээн зөвшөөрнө.

Орж ирнэ гэж тооцоолсон ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийг санхүүгийн хөрөнгийн анхны, үр ашигт хүүний хувиар бууруулан тооцдог. Зээлийн хүүний хувь нь хувьсах нөхцөлтэй бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих хөнгөлөлтийн хувь нь дахин ангилсан өдрөөрх өнөөгийн үр ашигт хүүний хувьтай тэнцүү байна.

Хөрөнгийн бүртгэлийн дүнг эрсдлийн сангийн дансаар бууруулах ба алдагдлын дүнг орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

Бүртгэлийн бууруулсан дүн дээр хүүний орлогыг үргэлжлүүлэн хуримтлуулах ба үнэ цэнийн бууралтын алдагдлыг хэмжих зорилгоор ирээдүйн мөнгөн урсгалыг бууруулахад ашиглахад ашигласан хүүний түвшингээр хуримтлуулна. Хүүний орлогыг санхүүгийн бүртгэлд орлого, зардлын дансанд бүртгэнэ.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

13) Санхүүгийн хэрэглүүрүүдийг цэвэршүүлэх

Хэрэв байгууллага нь хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэвэршүүлэх хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсвэл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа бол санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь цэвэршүүлэн, цэвэр дүнгээр нь тайлан тэнцэлд толилуулах эрхтэй.

14) Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх

Компанид эдийн засгийн өгөөж орох магадлалтай бөгөөд орлогыг хэмжиж тодорхойлох боломжтой болсон үед орлогыг хүлээн зөвшөөрнө.

Барааг нийлүүлэх буюу үйлчилгээг үзүүлсэн үед орлогыг хүлээн зөвшөөрдөг.

(i) Бараа, үйлчилгээний борлуулалт

- Компани нь ажил үйлчилгээний эдийн засгийн өгөөжийг хүртэх магадлалтай,
- Компани нь бараа үйлчилгээний өмчлөлтэй холбогдсон мэдэгдэхүйц эрсдэл ба өгөөжийг худалдан авагч талд шилжүүлсэн,
- Орлогын дүнг найдвартай хэмжих боломжтой,
- Бараа үйлчилгээтэй холбогдон гарсан болон гарах зардлыг найдвартай хэмжих боломжтой.

(ii) Худалдан авагчтай байгуулсан гэрээний орлого

Тайлант хугацааны худалдан авагчтай байгуулсан гэрээний орлогыг дараах алхмаар тодорхойлж хүлээн зөвшөөрнө. - 16

- Худалдан авагчтай байгуулсан гэрээг тодорхойлох,
- Гүйцэтгэлийн үүргүүдийг тодорхойлох,
- Ажил гүйлгээний үнийг тодорхойлох,
- Ажил гүйлгээний үнийг хуваарилах,
- Орлого хүлээн зөвшөөрөх

Гэрээний орлого нь анх байгуулсан гэрээгээр тохиролцсон дүн байх ба гэрээгээр зохицуулснаас гадуурх ажлын өөрчлөлт урамшууллын орлого нь ихэнх тохиолдолд орлогоор бүртгэгдэх ба тэдгээр нь бодитоор хэмжигдэх боломжтой байна.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

14) Орлого, зардлыг хүлээн зөвшөөрөх (үргэлжлэл)

(iii) Өртөг зардлыг хүлээн зөвшөөрөх

Нягтлан бодох бүртгэлийн хугацаанд эдийн засгийн үр өгөөж буурах буюу хөрөнгө гадагшлах эсвэл хөрөнгийн бууралт, эзний өмчийг бууруулах үр дагавар бүхий өр төлбөрийн үүсэлт, эздэд хуваарлигдахаас бусад зүйлс орно.

Өртөг зардлыг орлогын хүлээн зөвшөөрөлттэй уялдуулан аккрузл сууриар, бодит дүнгээр хүлээн зөвшөөрдөг. Гэрээний өртөг нь тухайн гэрээтэй шууд холбогдсон зардал байх ба гэрээнд хамаатуулж болох бусад зардлыг гэрээнд хуваарилж болно.

15) Татвар

(i) Тайлант хугацааны орлогын албан татвар

Тайлант үеийн татвар гэдэг нь тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр мөрдөж буй татварын хувь хэмжээг ашиглан тайлант үеийн татвар ногдох орлогоос тооцож төлөх татварын өглөг болон өмнөх тайлант хугацаанд хамаарах тайлант үеийн татварыг түүний төлөгдөөгүй байгаа дүнгээр татварын өр төлбөр гэж хүлээн зөвшөөрнө.

(ii) Хойшлуулсан орлогын албан татвар

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлагналын өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн дансны үнэ болон тэдгээрийн татварын суурь хоорондын түр зөрүүнээс тооцоолж хүлээн зөвшөөрдөг.

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн дансны үнийг санхүүгийн тайлангийн өдөр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг дансны үнийг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Хэрэв хуулиар хэрэгжүүлэх эрх нь үүссэн бол нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хооронд нь цэвэршүүлэн тайлагнаж болно.

16) Эздийн өмч

(i) Хувьцаат хөрөнгө

Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

1. НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО (ҮРГЭЛЖЛЭЛ)

1.2 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУДЫН ХУРААНГУЙ (үргэлжлэл)

(анхны хүлээн зөвшөөрөлт ба дараагийн тайлант үеийн хэмжилт)

16) Эздийн өмч (үргэлжлэл)

(ii) Хуримтлагдсан ашиг

Хуримтлагдсан ашиг нь тухайн тайлант хугацаанд хуримтлуулсан нийт ашиг, алдагдлын дүнгээс зарлагдсан ногдол ашгийг хассан дүнгээр тодорхойлогдох ба өмнөх үеийн залруулга болон нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөөллийг тусгасан байж болно.

17) Холбоотой талуудын ажил гүйлгээ

Холбоотой талууд гэдэгт Компанитай дараах байдлаар холбогдсон аж ахуйн нэгж болон хувь хүн орно. Үүнд:

(а) Компанитай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсвэл тухайн хувь хүний ойрын төрөл садан:

- (i) Компанид дангаараа эсвэл хамтран хяналт тогтоосон;
- (ii) Компанид томоохон нөлөөлөлтэй эсвэл
- (iii) Компанийн эсвэл Компанийн толгой компанийн гол удирдах албан тушаалтнуудын нэг.

(б) Дараах нөхцлүүдийн аль нэг нь биелсэн тохиолдолд аж ахуй нэгж нь Компанид хамааралтай болно. Үүнд:

- (i) Аж ахуй нэгж нь нэг ижил группийн гишүүд байх (толгой компани, охин компани болон нөгөө охин компани тус бүр нь бусадтайгаа холбоотой).
- (ii) Нэг аж ахуй нэгж нь нөгөө аж ахуй нэгжийн хараат компани эсвэл хамтын хэлэлцээрт компани (эсвэл нөгөө аж ахуй нэгж нь гишүүн болох группийн хараат компани эсвэл хамтарсан хэлэлцээрт компани).
- (iii) Аль аль аж ахуй нэгж нь нэг ижил гуравдагч этгээдийн хамтарсан хэлэлцээрт компаниуд. - 18
- (iv) Нэг аж ахуй нэгж нь гуравдагч аж ахуй нэгжийн хамтарсан хэлэлцээрт компани бөгөөд нөгөө этгээд нь гуравдагч аж ахуй нэгжийн хараат компани.
- (v) Аж ахуй нэгж нь Компанийн эсвэл Компанитай холбоотой аж ахуй нэгжийн ажиллагсдыг урамшуулах зорилгоор ажил эрхлэлтийн дараах тэтгэмж олгодог. Хэрвээ Компани нь уг хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бол дэмжлэг хүртэж буй ажиллагсад нь мөн Компанитай холбоотой тал болно.
- (vi) Аж ахуй нэгжийг (а)-д тодорхойлсон хувь хүн дангаараа эсвэл хамтран хяналт тогтоодог.

(vii) (а) (i)-д тодорхойлсон хувь хүн нь аж ахуй нэгжид томоохон нөлөөлөлтэй эсвэл уг аж ахуй нэгжийн (эсвэл аж ахуй нэгжийн толгой компанийн) гол удирдах албан тушаалтнуудын нэг.

(viii) Аж ахуй нэгж нь эсвэл группийн аль нэг гишүүн нь Компани эсвэл Компанийн толгой компанид гол удирдах албан тушаалтай байх.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2. МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

(төгрөгөөр)

№	Мөнгөн хөрөнгийн зүйлс	2024-12-31		2025-12-31	
		Валют	Төгрөг	Валют	Төгрөг
Касс дахь бэлэн мөнгө					
1	Касс дахь бэлэн мөнгө	MNT			
2	Касс дахь бэлэн мөнгө	RUB	1,206.00		
Дүн			8,098,841.10		
Банкин дахь мөнгө					
1	Банкин дахь харилцах данс	MNT			
2	Банкин дахь харилцах данс	USD	796.94	14.72	
3	Банкин дахь харилцах данс	CNY	209.67	90.00	
Дүн			65,448,604.12		
Мөнгөтэй адилтгах хөрөнгө					
1	Хадгаламж зээлийн хоршоон дахь хуримтлал	MNT			
Дүн			92,000,000.00		
Нийт дүн			165,547,445.22		

Компанийн мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө болон банкин дахь харилцах дансаас бүрдэнэ. Харилцах дансанд хязгаарлалт, битүүмж байхгүй тул богино хугацаанд ашиглагдах боломжтой. Мөнгөн хөрөнгийг богино хугацаанд хөрвөх чадвартай, эрсдэл багатай хөрөнгө гэж ангилсан.

3. ДАНСНЫ АВЛАГА

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Дансны авлага	Найдваргүй авлагын хасагдуулга	Дансны авлага (цэвэр дүнгээр)
	2024 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	34,717,306.95		34,717,306.95
1	Нэмэгдсэн (+)	8,868,411,676.50		8,868,411,676.50
2	Хасагдсан (-) :	8,828,815,769.27	0.00	8,828,815,769.27
	Төлөгдсөн	8,828,815,769.27		8,828,815,769.27
	Найдваргүй болсон			0.00
	Найдваргүй авлагын хасагдуулгын тохируулга		- 19	0.00
	2025 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	74,313,214.18	0.00	74,313,214.18

Дансны авлагыг цэвэр дүнгээр тайлагнасан бөгөөд найдваргүй авлагын хасагдуулга хийгдээгүй. Авлагын эргэн төлөлт хугацаандаа хийгдсэн тул эрсдэл бага гэж үнэлэгдсэн. Авлагын эргэн төлөлтийн хугацаа, эрсдэлийн удирдлагын бодлого, холбоотой талуудын авлагын мэдээллийг тусад нь тайлбарласан.

4. ТАТВАРЫН АВЛАГА

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
1	Онцгой албан татвар	5,524,056.15	19,453,659.84
	Нийт дүн	5,524,056.15	19,453,659.84

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

5. БУСАД БОГИНО ХУГАЦААТ АВЛАГА

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
1	Холбоотой талаас авах авлагын тайлант хугацаанд хамаарах нь	676,426,590.05	678,107,927.56
2	Ажиллагсдаас авах авлага	104,643,346.90	98,389,023.29
3	Хувь хүнээс авах авлага	11,918,458.91	4,816.00
Нийт дүн		792,988,395.86	776,501,766.85

6. БАРАА МАТЕРИАЛ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	Нэмэгдсэн дүн	Хасагдсан дүн (-)	2025-12-31
1	Түүхий эд, материал	1,158,563,624.21	3,754,906,014.29	3,014,191,871.09	1,899,277,767.41
2	Хангамжийн материал	41,177,544.70	48,292,613.26	42,392,360.27	47,077,797.69
3	Сэлбэг хэрэгсэл	16,184,089.22	56,942,351.37	44,067,911.56	29,058,529.03
4	Дуусаагүй үйлдвэрлэл	0.00	3,392,859,312.24	3,392,859,312.24	0.00
5	Бэлэн бүтээгдэхүүн	534,909,700.11	3,655,132,862.26	3,136,910,942.76	1,053,131,619.61
6	Бараа бүтээгдэхүүн	148,075,701.47	1,071,144,109.37	1,010,498,556.52	208,721,254.32
7	Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	5,520,857.03	31,806,636.32	16,070,505.62	21,256,987.73
8	Цэвэрлэгээний материал	872,542.29	10,132,881.35	8,207,896.68	2,797,526.96
9	Барилгын материал	57,171,958.09	60,905,707.88	20,694,879.28	97,382,786.69
10	Хүнс, мах ногоо	6,251,914.31	19,022,272.75	19,537,668.01	5,736,519.05
11	Бичиг хэргийн материал	1,314,207.38	3,229,863.65	3,654,273.05	889,797.98
Нийт дүн		1,970,042,138.81	12,104,374,624.74	10,709,086,177.08	3,365,330,586.47

Дуусаагүй үйлдвэрлэлийг өртгийн зарчмаар бүртгэсэн. Бараа материалын үнэлгээг “Өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль бага”-аар хэмжсэн.

7. УРЬДЧИЛЖ ТӨЛСӨН ЗАРДАЛ/ТООЦОО

- 20 (төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
1	Урьдчилж төлсөн зардал	2,880,000.00	2,880,000.00
2	Урьдчилж төлсөн тооцоо	58,179,462.87	72,672,864.91
Нийт дүн		61,059,462.87	75,552,864.91

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

8. ҮНДСЭН ХӨРӨНГӨ

(төгрөгөөр)								
№	Үзүүлэлт	Барилга байгууламж	Машин, тоног төхөөрөмж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, бусад хэрэгсэл	Бусад үндсэн хөрөнгө	Нийт дүн
ҮНДСЭН ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/								
1.1	2024 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	1,082,857,266.07	2,153,636,065.89	506,526,857.24	88,440,372.36	97,988,623.30	91,540,682.34	4,020,989,867.20
1.2	Нэмэгдсэн дүн	0.00	72,770,912.00	0.00	43,587,430.10	8,243,454.55	498,300.17	125,100,096.82
	Их засвар							0.00
	Худалдаж авсан		72,770,912.00		43,587,430.10	8,243,454.55	498,300.17	125,100,096.82
	Өмнөх үеийн залруулга							0.00
	Дахин үнэлгээний нэмэгдэл							0.00
1.3	Хасагдсан дүн (-)	0.00	0.00	0.00	90,000.00	69,090.90	0.00	159,090.90
	Худалдсан							0.00
	Өмнөх үеийн залруулга							0.00
	Акталсан				90,000.00	69,090.90		159,090.90
	Дахин үнэлгээний нэмэгдэл буцаав							0.00
1.4	Үндсэн хөрөнгө дахин ангилсан							0.00
1.5	Үндсэн хөрөнгө, ХОЗҮХХ хооронд дахин ангилсан							0.00
1.6	2025 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	1,082,857,266.07	2,226,406,977.89	506,526,857.24	131,937,802.46	106,162,986.95	92,038,982.51	4,145,930,873.12
ХУРИМТЛАГДСАН ЭЛЭГДЭЛ								0.00
2.1	2024 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	365,990,959.40	1,574,202,862.49	225,595,071.93	43,407,578.70	80,874,216.83	44,973,407.42	2,335,044,096.77
2.2	Нэмэгдсэн дүн	28,327,527.84	123,886,836.74	40,700,685.96	9,819,382.38	13,745,844.27	6,589,907.47	223,070,184.66
	Байгуулсан элэгдэл	28,327,527.84	123,886,836.74	40,700,685.96	9,819,382.38	13,745,844.27	6,589,907.47	223,070,184.66
	Дахин үнэлгээгээр нэмэгдсэн							0.00
	Үнэ цэнийн бууралтын буцаалт							0.00
2.3	Хасагдсан дүн	0.00	0.00	0.00	24,919.42	69,090.90	0.00	94,010.32
	Данснаас хассан хөрөнгийн элэгдэл				24,919.42	69,090.90		94,010.32
	Дахин үнэлгээгээр хасагдсан							0.00
	Үнэ цэнийн бууралт							0.00
2.4	2025 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	394,318,487.24	1,698,089,699.23	266,295,757.89	53,202,041.66	94,550,970.20	51,563,314.89	2,558,020,271.11
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН								0.00
3.1	2024 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	716,866,306.67	579,433,203.40	280,931,785.31	45,032,793.66	17,114,406.47	46,567,274.92	1,685,945,770.43
3.2	2025 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	688,538,778.83	528,317,278.66	240,231,099.35	78,735,760.80	11,612,016.75	40,475,667.62	1,587,910,602.01

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

9. БИЕТ БУС ХӨРӨНГӨ

(төгрөгөөр)							
№	Үзүүлэлт	Компьютерийн програм хангамж	Патент	Барааны тэмдэг	Тусгай зөвшөөрөл	Газар эзэмших эрх	Нийт дүн
БИЕТ БУС ХӨРӨНГӨ /ӨРТӨГ/							
1.1	2024 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	21,641,777.66	3,667,027.94	0.00	24,305,556.00	179,179,658.00	228,794,019.60
1.2	Нэмэгдсэн дүн	840,000.00	9,217,400.00	0.00	50,000,000.00	0.00	60,057,400.00
	Өөрөө үйлдвэрлэсэн						0.00
	Худалдаж авсан	840,000.00	9,217,400.00		50,000,000.00		60,057,400.00
	Үнэ төлбөргүй авсан						0.00
	Дахин үнэлгээний нэмэгдэл						0.00
1.3	Хасагдсан дүн (-)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
	Худалдсан						0.00
	Үнэгүй шилжүүлсэн						0.00
	Акталсан						0.00
	Дахин үнэлгээний нэмэгдэл буцаалт						0.00
1.4	2025 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	22,481,777.66	12,884,427.94	0.00	74,305,556.00	179,179,658.00	288,851,419.60
ХУРИМТЛАГДСАН ХОРОГДОЛ							
2.1	2024 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	13,770,877.83	3,667,027.94	0.00	16,666,666.68	0.00	34,104,572.45
2.2	Нэмэгдсэн дүн	5,202,444.22	3,072,466.68	0.00	10,402,778.23	0.00	18,677,689.13
	Байгуулсан хорогдол	5,202,444.22	3,072,466.68		10,402,778.23		18,677,689.13
	Дахин үнэлгээгээр нэмэгдсэн						0.00
	Үнэ цэнийн бууралтын буцаалт						0.00
2.3	Хасагдсан дүн (-)	0.00	0.00	0.00	0.00	0.00	0.00
	Данснаас хассан хөрөнгийн хорогдол						0.00
	Дахин үнэлгээгээр хасагдсан						0.00
	Үнэ цэнийн бууралт						0.00
2.4	2025 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	18,973,322.05	6,739,494.62	0.00	27,069,444.91	0.00	52,782,261.58
ДАНСНЫ ЦЭВЭР ДҮН							
3.1	2024 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	7,870,899.83	0.00	0.00	7,638,889.32	179,179,658.00	194,689,447.15
3.2	2025 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	3,508,455.61	6,144,933.32	0.00	47,236,111.09	179,179,658.00	236,069,158.02

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

10. ДАНСНЫ ӨГЛӨГ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
	Төлөгдөх хугацаандаа байгаа :		
1	Бэлтгэн нийлүүлэгчдэд төлөх өглөг	8,968,855.61	21,498,177.86
	Нийт дүн	8,968,855.61	21,498,177.86

Дансны өглөгийг богино хугацаанд төлөх өр төлбөрийн ангилалд багтаасан. Хугацаа хэтэрсэн өглөг байхгүй.

11. ЦАЛИНГИЙН ӨГЛӨГ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
1	Цалингийн өглөг	40,040,301.33	37,384,324.29
	Нийт дүн	40,040,301.33	37,384,324.29

12. ТАТВАРЫН ӨР

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
1	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар	72,045,652.48	130,489,968.80
2	Нэмэгдсэн өртгийн албан татвар	20,073,373.49	8,318,643.48
3	Хувь хүний орлогын албан татвар	23,650,530.68	31,136,057.61
4	Бусад татвар өр	244,747.00	641,929.00
	Нийт дүн	116,014,303.65	170,586,598.89

Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, НӨАТ, Хувь хүний орлогын албан татварын өрийг тусад нь тайлагнасан. Татварын өрийн өсөлт нь тайлант үеийн үйл ажиллагааны үр дүнтэй холбоотой.

13. НИЙГМИЙН ДААТГАЛЫН ШИМТГЭЛИЙН ӨР

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
1	Нийгмийн даатгалын шимтгэл	1,814,607.23	20,828,514.39
	Нийт дүн	1,814,607.23	20,828,514.39

НДШ-ийн өглөгийн тооцооллыг хууль тогтоомжийн дагуу хийсэн.

14. БОГИНО ХУГАЦААТ ЗЭЭЛ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31		2025-12-31	
		Валютаар	Төгрөгөөр	Валютаар	Төгрөгөөр
	Төлөгдөх хугацаандаа байгаа :				
1	ХААН банкны богино хугацаат зээл		275,000,000.00		0.00
	Хугацаа хэтэрсэн :				
	Нийт дүн	0.00	275,000,000.00	0.00	0.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

15. ХҮҮНИЙ ӨР ТӨЛБӨР

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
1	Хүүний өглөг	65,479.45	0.00
	Нийт дүн	65,479.45	0.00

16. БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ТОДРУУЛГА

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31		
			Улсын байгууллагад төлөх өр	Хувийн байгууллагад төлөх өр	Дүн
1	Дансны өглөг	8,968,855.61		21,498,177.86	21,498,177.86
2	Цалингийн өглөг	40,040,301.33		37,384,324.29	37,384,324.29
3	Татварын өр	116,014,303.65	170,586,598.89		170,586,598.89
4	НДШ -ийн өглөг	1,814,607.23	20,828,514.39		20,828,514.39
5	Богино хугацаат зээл	275,000,000.00			0.00
6	Хүүний өглөг	65,479.45			0.00
	Нийт дүн	441,903,547.27	191,415,113.28	58,882,502.15	250,297,615.43

17. ЭЗДИЙН ӨМЧ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Эргэлтэнд байгаа бүрэн төлөгдсөн энгийн хувьцаа		Өмчийн дүн
		Тоо ширхэг	Дүн (төг)	
1	2024 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	112,716	11,271,600.00	11,271,600.00
2	Нэмэгдсэн			0.00
3	Хасагдсан (-)			0.00
	2025 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	112,716	11,271,600.00	11,271,600.00

Энгийн хувьцааны тоо хэмжээ, дүнг тайлагнасан. Тайлант хугацаанд хувьцааны өөрчлөлт хийгдээгүй.

18. НЭМЖ ТӨЛӨГДСӨН КАПИТАЛ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
1	Энгийн хувьцааны нэмж төлөгдсөн капитал	3,465,126.06	3,465,126.06
	Нийт дүн	3,465,126.06	3,465,126.06

19. ХӨРӨНГИЙН ДАХИН ҮНЭЛГЭЭНИЙ НЭМЭГДЭЛ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Нийт дүн
1	2024 оны 12 дугаар сарын 31 -ний үлдэгдэл	847,420,494.00	847,420,494.00
2	Нэмэгдсэн дүн	0.00	0.00
3	Хасагдсан дүн (-)	0.00	0.00
	2025 оны 12 дугаар сарын 31 -ны үлдэгдэл	847,420,494.00	847,420,494.00

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

20. ЭЗДИЙН ӨМЧИЙН БУСАД ХЭСЭГ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
1		179,179,658.00	179,179,658.00
	Нийт дүн	179,179,658.00	179,179,658.00

21. ХУРИМТЛАГДСАН АШИГ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024-12-31	2025-12-31
1	Тайлант оны эхний үлдэгдэл	2,484,562,584.13	3,427,273,598.11
2	Тайлант үеийн ашиг	942,711,013.98	1,634,484,091.43
	Нийт дүн	3,427,273,598.11	5,061,757,689.54

22. БОРЛУУЛАЛТЫН ОРЛОГО БОЛОН БОРЛУУЛАЛТЫН ӨРТӨГ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024	2025
	Борлуулалтын орлого :	5,630,639,979.70	8,135,475,648.28
	Борлуулалтын хөнгөлөлт, буцаалт :	38,505,629.06	336,850,802.99
	Борлуулалтын хөнгөлөлт	1,213,458.95	8,992,825.29
	Борлуулалтын буцаалт	37,292,170.11	327,857,977.70
	Цэвэр борлуулалт :	5,592,134,350.64	7,798,624,845.29
	Борлуулалтын өртөг :	3,206,906,508.99	4,417,453,834.52
	Нийт ашиг	2,385,227,841.65	3,381,171,010.77

23. БОРЛУУЛАЛТЫН ӨРТГИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024	2025
1	Цалингийн зардал	271,933,284.60	363,213,369.55
2	НДШ -ийн зардал	33,812,083.02	42,774,413.56
3	Материалын зардал	1,893,666,702.87	3,222,586,273.45
4	Түрээсийн зардал		77,298,222.12
5	Элэгдэл, хорогдлын зардал	80,031,593.35	111,896,466.84
6	Бусад	927,462,845.15	599,685,089.00
	Нийт дүн	3,206,906,508.99	4,417,453,834.52

24. БУСАД ОРЛОГО

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024	2025
1	Хүүний орлого	0.00	14,806,647.80
	Нийт дүн	0.00	14,806,647.80

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

25. БОРЛУУЛАЛТ, МАРКЕТИНГИЙН ЗАРДАЛ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024	2025
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	160,340,991.23	189,372,207.25
2	НДШ-ийн зардал	15,753,795.57	20,336,351.16
3	Албан татвар, төлбөр хураамжийн зардал		
4	Албан томилолтын зардал	184,400.00	
5	Бичиг хэргийн зардал	2,637,237.28	2,404,586.38
6	Шуудан холбоо, интернет сүлжээний зардал		393,590.90
7	Мэргэжлийн үйлчилгээний зардал	129,000.00	42,000,672.50
8	Сургалтын зардал	1,400,000.00	
9	Даатгалын зардал	74,250.00	
10	Ашиглалтын зардал	10,786,294.43	12,803,636.37
11	Урсгал засварын зардал	18,533,570.65	2,209,164.37
12	Элэгдэл, хорогдлын зардал	17,440,081.30	15,597,215.68
13	Түрээсийн зардал	21,600,000.00	26,400,000.00
14	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	397,356.02	430,596.10
15	Тээврийн зардал	512,000.00	320,000.00
16	Түлш шатахуун, тослох материалын зардал	19,530,879.91	8,048,027.07
17	Ёслол хүндэтгэл, арга хэмжээний зардал	63,620.90	
18	Зар сурталчилгааны зардал	7,268,586.95	1,717,044.98
19	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын зардал	1,688,360.85	2,829,574.43
20	Үндсэн үйл ажиллагааны бусад зардал	27,421,779.97	1,667,527.19
Нийт дүн		305,762,205.06	326,530,194.38

26. ЕРӨНХИЙ БА УДИРДЛАГЫН ЗАРДАЛ

(төгрөгөөр)

№	Үзүүлэлт	2024	2025
1	Үндсэн ба нэмэгдэл цалин	490,231,851.99	607,671,444.61
2	НДШ-ийн зардал	53,427,946.75	61,959,430.94
3	Албан татвар, төлбөр хураамжийн зардал	13,416,894.25	15,914,972.25
4	Албан томилолтын зардал	24,538,716.35	26,866,931.01
5	Бичиг хэргийн зардал	5,550,103.97	3,845,800.14
6	Шуудан холбоо, интернет сүлжээний зардал	7,438,725.31	10,792,465.64
7	Мэргэжлийн үйлчилгээний зардал	18,803,918.18	94,402,595.57
8	Сургалтын зардал	2,390,000.00	5,482,691.03
9	Даатгалын зардал	2,148,060.00	1,378,764.00
10	Ашиглалтын зардал	20,675,641.06	31,146,022.06
11	Урсгал засварын зардал	58,517,712.67	66,356,008.82
12	Элэгдэл, хорогдлын зардал	128,042,236.30	114,254,191.27
13	Түрээсийн зардал	10,780,000.00	6,720,000.00
14	Цэвэрлэгээ үйлчилгээний зардал	8,877,770.27	12,504,050.10
15	Тээврийн зардал	229,000.00	2,477,409.26
16	Түлш шатахуун, тослох материалын зардал	30,121,597.94	19,308,991.45
17	Ёслол хүндэтгэл, арга хэмжээний зардал	13,932,754.79	6,492,708.88
18	Зар сурталчилгааны зардал	1,553,938.09	1,358,017.88
19	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй байдлын зардал	9,969,476.88	19,084,644.78
20	Үндсэн үйл ажиллагааны бусад зардал	51,717,398.29	61,861,938.23
Нийт дүн		952,363,743.09	1,169,879,077.92

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

27. БУСАД ЗАРДАЛ

(төгрөгөөр)			
№	Үзүүлэлт	2024	2025
1	Санхүүгийн зардал	58,461,625.90	53,798,042.66
-	Зээлийн хүүний зардал	58,461,625.90	13,292,334.57
-	Банк, санхүүгийн үйлчилгээний зардал		40,505,708.09
2	Бусад зардал	22,390,454.12	28,305,779.34
-	Алданги, хүү торгуулийн зардал	234,600.00	335,000.00
-	Хандив, тусламжийн зардал	22,155,854.12	27,970,779.34
	Нийт дүн	80,852,080.02	82,103,822.00

28. ГАДААД ВАЛЮТЫН ХАНШИЙН ЗӨРҮҮНИЙ ОЛЗ, ГАРЗ

(төгрөгөөр)			
№	Үзүүлэлт	2024	2025
	Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз, гарз :		
1	Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд хийсэн ханшийн тэгшитгэл	993,125.40	1,655,134.04
2	Эргэлтийн авлага, өр төлбөртэй холбоотой үүссэн ханшийн зөрүү		
	Нийт дүн	993,125.40	1,655,134.04

29. БУСАД АШИГ (АЛДАГДАЛ)

(төгрөгөөр)			
№	Үзүүлэлт	2024	2025
1	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз, гарз	2,591,222.44	(65,080.58)
	Нийт дүн	2,591,222.44	(65,080.58)

30. ОРЛОГЫН ТАТВАРЫН ЗАРДАЛ

(төгрөгөөр)			
№	Үзүүлэлт	2024	2025
1	Тайлант үеийн орлогын татварын зардал	107,123,147.34	184,570,526.30
	Нийт дүн	107,123,147.34	184,570,526.30

Тайлант үеийн орлогын татварын зардлыг тусад нь тайлагнасан. Үндсэн үйл ажиллагааны үр дүнтэй уялдуулан тайлбарласан. Татварын зардлын тооцооллыг хууль тогтоомжийн дагуу хийсэн.

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГУУД

2025 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31–НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

31. ЦАЛИНГИЙН ЗАРДАЛ

№	Зардлын төвүүд	(төгрөгөөр)			
		2024		2025	
		Ажилчдын тоо	Цалингийн зардал	Ажилчдын тоо	Цалингийн зардал
1	Үйлдвэрлэл, үйлчилгээний :		271,933,284.60		363,213,369.55
2	Борлуулалт, маркетингийн :		160,340,991.23		189,372,207.25
3	Ерөнхий ба удирдлагын :		490,231,851.99		607,671,444.61
	Нийт дүн	0	922,506,127.82	0	1,160,257,021.41

32. ТАЙЛАГНАЛЫН ҮЕИЙН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Бид тайлагналын өдрөөс хойш болсон үйл явдлуудыг авч үзсэн бөгөөд санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд материаллаг нөлөө үзүүлэхүйц үйл явдал илрээгүй байна.

33. ТАСРАЛТГҮЙ АЖИЛЛАГАА

Удирдлага нь байгууллагын үйл ажиллагааг тайлагналын өдрөөс хойш дор хаяж 12 сарын хугацаанд хэвийн үргэлжлэх чадвартай гэж үнэлсэн. Бид менежментийн үнэлгээг хянаж, санхүүгийн болон үйл ажиллагааны мэдээлэлд тулгуурлан дүгнэлт хийсэн бөгөөд байгууллагын тасралтгүй үйл ажиллагаанд эргэлзээ төрүүлэхүйц материаллаг тодорхойгүй байдал илрээгүй байна.